



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2018.08.23 № 5/3401

танай _____ -ны № _____ -г

Тайлан ирүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Үндэсний хөтөлбөр, Хүний эрхийг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараах тайлан, мэдээг гаргаж Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт тус тус хүргүүлдэг.

Мөн 2019 оны 01 сард НҮБ-ын Хүний эрхийн тайлан хэлэлцэхтэй холбоотойгоор Хүний эрхийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 2018 онд багтаан хэрэгжүүлж дуусгах талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж, 2018.05.04-ний 1-1/2188 дугаартай албан бичгээр албан даалгавар өгөгдөж, Хүний эрхийн чиглэлээр хийгдсэн ажлын тайланг 2018.12.01-ний дотор ХЗДХЯ-нд хүргүүлнэ. Иймд Үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан асуудлын хүрээнд хийгдсэн ажлын тайлан, мэдээг дор дурьдсан хугацааны дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Хүний эрхийг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018.11.20-ны дотор
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018.11.20-ны дотор
3. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018.11.20-ны дотор
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018.11.20-ны дотор
5. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018.12.01-ний дотор
6. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2018.11.20-ны дотор
7. Засгийн газрын 2017 оны 01 дугаартай "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" албан даалгаврын хэрэгжилтийг 2018.12.01-ний дотор

Жич: Дээр дурьдсан Үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсарган хүргүүлэв.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЦОГТБААТАР



086969



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 086

Улаанбаатар хот

**“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний
байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг
хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга
хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.5 дахь заалт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд дэвшүүлсэн санал, зөвлөмжийг үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ НЬ:

НЭГ.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд дэвшүүлсэн санал, зөвлөмжийг сайшаасугай.

ХОЁР.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд дэвшүүлсэн санал зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч, ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай:

1.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар

1.1.Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгаж, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах арга хэмжээ авах.

1.2.Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, шүүхэд сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлал, нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх зэргээр хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах.

1.3.Өсвөр насны охид эрт бэлгийн харилцаанд орох, хүүхэд төрүүлэх, үр хөндүүлэх, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвдөх нь жилээс жилд нэмэгдэж байгааг онцгойлон анхаарч, энэ чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

1.4.Баян-Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг төрийн албан ёсны хэл дээр явуулах

4.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний шинэ хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.

4.3.Жендэрийн эрх тэгш байдал гэдэг нь жендэрийн тэгш байдал гэсэн ойлголтын нэг хэсэг тул уг хуулийн нэрийг "Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль" гэж өөрчлөх асуудлыг судалж, холбогдох журмын дагуу шийдвэрлэх.

4.4.Төр, захиргааны байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хүлээсэн чиг үүргийнхээ хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл гаргадаг байх журмын зохицуулалтыг хуульд шинээр тусгах.

ГУРАВ.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2017 оны 12/28 дугаар тогтоолоор байгуулагдсан хамтарсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийн талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай:

1.Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомж шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдал үүсэж байгаа тул дээрх хуулиудын зарим зүйл, заалт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэхийг судалж, шийдвэрлэх.

3.Хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх асуудлыг зохицуулсан журмыг хүчингүй болгож уг асуудлыг Гэр бүлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

4.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14, 16 дугаар зүйлд заасан дүрэм, журмыг баталж, чиг үүргээ биелүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж, ажиллах.

5.Эрүүл мэндийн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, ажиллах.

6.Олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллага Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах асуудлыг тусгах, хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхийг хориглосон заалтыг чанд мөрдөж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргээ биелүүлж ажиллах.

18.Хэрэгцээ хөнөөлийг зохицуулах хороо, цагдаагийн байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зур сурталчилгаа, цахим сүлжээгээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

19.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжийг байгуулан ажиллуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх ажилд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтныг оролцуулах.

20.Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд "Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

ДӨРӨВ.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тайлагнахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

ТАВ.Энэ тогтоолын биелэлтэд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Д.Ш.Раднаасэд/ хяналт тавьж ажилласугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.РАДНААСЭД



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2018.08.04 № 1-1/2188

танай _____-ны № _____-т

Төлөвлөгөөний тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн явцыг Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд төлөвлөгөөний хэрэгжилтээс удаашралтай байгаа болон хэрэгжиж эхлээгүй арга хэмжээнүүдийг 2018 онд багтаан хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон билээ.

Ерөнхий төлөвлөгөөний дараахь арга хэмжээнүүд Таны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа болно. Үүнд:

Гурав. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр:

① Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлаарх журам боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;

② Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн, хараат бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд тулгуурлан цаашдын стратеги, хөтөлбөрөө холбогдох төрийн бус байгууллагын оролцоотой боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах, эхийн эндэгдлийн түвшинг 2015 оны түвшингээс бууруулах;

Тав. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр

③ Гэр бүлийн хүчирхийлэл, түүний учир шалтгаан, хор хохирол, үр дагаврыг нийгэмд таниулах, мөн урьдчилан сэргийлэх зан зүйлийг сэдэлжүүлэх зорилгоор мэдээлэл, сургалт, танин мэдэхүйн хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгох;

④ Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээг аймгуудад үе шаттайгаар бий болгох;

Ес. Ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр

⑤ ЛГБТ хүмүүс зэрэг нийгмийн цөөнх бүлгүүдийн нийт гишүүний эрхийг хамгаалах зорилго бүхий ялгаварлан гадуурхахын эсрэг аян зохион байгуулж, нийгэмд тогтсон буруу ойлголт, хандлагыг өөрчлөх чиглэлээр ажиллах;

6. Улс төрийн үзэл бодлын улмаас шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхагдахгүй байх нөхцөлийг хангах, төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдын тогтвортой ажиллах нөхцөлийг хангах;
Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах;

7. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт бүхий Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох;

8. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотойгоор эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн дундах ялгаварлан гадуурхалтыг бууруулах, ээлтэй үйлчилгээ бий болгох;

9. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, Дархлалын олдмол хомсдолын халдвар авах эрсдэл өндөртэй бэлгийн цөөнх эрэгтэйчүүд, бие үнэлэгч эмэгтэйчүүд, хар тамхи мансууруулах бодис судсаар хэрэглэгчид, хүний дархлал хомсдолын вирусийн халдвартай амьдарч байгаа гэх зэрэг бүлгийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг бууруулах, үйлчилгээний ээлтэй орчинг бүрдүүлж, эрүүл мэндийн эрх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох;

Арван хоёр. Бусад

10. Эрүүл мэндийн суурь үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ болон хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх;

11. Эрүүл мэндийн суурь үйлчилгээний статистик мэдээллийг тогтмол шинэчилж, ил тод, нээлттэй мэдээлэх зэрэг болно.

Монгол Улсын Засгийн газраас 2019 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит 3 дахь тайланг хүргүүлэх юм.

Иймд дээр дурдсан арга хэмжээг 2018 онд багтаан хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох яамд, агентлаг, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж дуусган, хэрэгжилтийн тайланг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус яаманд ирүүлэхийг хүсье.

 Ш.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/501

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн комиссоос гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын хүний эрхийг хангах 2017-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилттэй холбогдох төсвийг жил бүр Эрүүл мэндийн яамны төсөвт суулгахыг Бодлого төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/-т, Хэрэгжилтийн талаарх тайланг нэгтгэн жил бүрийн 06 дугаар болон 12 дугаар сард Хүний эрхийн комисст хүргүүлж байхыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

D:\barim\tushaal

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
2017-2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 17 сарын 14-ны өдрийн
150/1 дугаар тушаалын хавсралт

Үйл ажиллагаа	Хамтран ажиллах нэгж, байгууллага	Хариуцах газар, хэлтэс	Хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр өнөөгийн хууль тогтоомж, бодлогод цогц хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь тулгуурлан бодлогыг боловсронгуй болгох	ХШҮУДАГ БТГ	Хуулийн хэлтэс	2017-2019	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд нь тэдгээрийг боловсронгуй болгох талаар төслүүдийг боловсруулсан байна.
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрх, түүний дотор тэдгээрийн нөхөн үржихүй, хүчирхийлэлээс ангид байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад санал хургуулж туслуулах	НЭМИГ	ЭТГ	2018-2019	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад тус яамны санал тусгагдсан байна
Эрүүл мэндийн суурь тусламж үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ болон хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх боломжуудыг судлан үзэх	НЭМИГ ЭТГ	БТГ	2017-2019	Эрүүл мэндийн суурь үйлчилгээ нь одоо байгаа түвшингээсээ сайжирч, тухайн салбарын тогтолцоонд байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх боломжийг судлан арга хэмжээ авсан байна.

4	✓	Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг үнэлж, хөтөлбөрийн дараагийн үе шатны хөтөлбөрийг боловсруулах байгууллагад саналаа өгөх, санхүү хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлэх	ХШУДАГ БТГ ТЗУГ ЭЗСХ ЭМХТ	НЭМГ НЭМҮТ	2018-2019	Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хариуцлагын талаарх н хэвшмэл ойлголтыг ялгаварлан гадуурхах уламжл үйлийг өөрчлөх чиглэлээр хийгдсэн байна.
5	✓	Эх хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн, хараат бус хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд нь тулгуурлан цаашдын стратеги, хөтөлбөрөө холбогдох төрийн бус байгууллагын оролцоотой боловсруулж батлан, хэрэгжилтийг хангуулах	ЭТГ ХШУДАГ ЭХЭМҮТ	НЭМГ	2017-2019	Эхийн эндэгдлийн хувь хэмжээ түвшинөөс бууруулахад чиглэс: Тасралтгүй хийж хэрэгжүүлсэн б
6	✓	Орон нутаг болон хот суурин газар дахь хүүхдийн эндэгдлийн хувь хэмжээг бууруулах замаар зөрүүг арилгах чиглэлээр ажиллах	НЭМҮТ ЭХЭМҮТ НЭМГ	ЭТГ	2017-2019	Эх хүүхдийн эрүүл мэндийг х чиглэлээр "Эх, хүүхэд, нөхөн эрүүл мэндийн үндэсний хөтө, хэрэгжүүлэн эх, нялхсын зт орон нутаг болон хот, суурин г зөрүү буурсан байна.
7	✓	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ үзүүлэгчдийг чадаахижуулах үйл ажиллагааг зохион байгуулах	СЭЗХ НЭМҮТ	НЭМГ ЭТГ	2017-2019	Гэр бүлийн хүчирхийлэлд иргэдэд үйлчлэх эмнэлэгт тв нэг цэгийн үйлчилгээний төи нэмэгдэж, үйл ажиллагаага байна
8	✓	БЭДХ, ДОХ авах эрсдэл өндөртэй бэлгийн чөөнх эрчүүд, биеэ үнлэгч эмэгтэйчүүд, хар тамхи мансууруулах бодис судсаар хэрэглэгчид, хүний дархлал хомсдолын вирусийн халдвартай амьдарч байгаа гэх зэрэг бүлгийн эсрэг алгаварлан гадуурхалтыг бууруулах	ХӨСҮТ	НЭМГ	2017-2019	Үйлчилгээний ээлтэй орчинг нийгмийн үйлчилгээг илүү хүр болгох

9	ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж хууль, тогтоомжийг санал хүргүүлэх	НЭМҮТ ХӨСҮТ	НЭМГ	2017-2019	ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн ү бүхий хамгаалалт тогтоосон тогтоомжийг боловсруулахад хүргүүлж тусгуулсан байна
10	Гар артаар уурхай эрхэлж байгаа ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор тус салбар дахь мөнгөн усны хэрэглээг зохицуулсан үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд холбогдох саналыг хүргүүлэн төлөвлөгөөнд тусгах	НЭМҮТ	НЭМГ	2017-2019	Хөдөлмөрийн аюулгүй байдал ахуйн үндэсний 5 дахь хөтө хэрэгжилтийг хангаж, мөнгө хэрэглээг зохицуулах үйл ажил төлөвлөгөө боловсруулан хэрэг байна
11	Өсвөр насны охидын жирэмслэлт, ураг зулбалт, үр хөндүүлэлт, төрөлтийн талаарх судалгааг үндэсний хэмжээнд нэгтгэн бүртгэж, судалгаа гаргадаг байх	НЭМҮТ	НЭМГ БТГ	2018-2019	Улсын болон хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагууд мэдээллийг нэгтгэн, мэдээллийн нэгдсэн сантай бол
12	Иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, өсвөр насны охидын төрөлт, ураг зулбалт, үр хөндөлтийн талаарх мэдээллийг нэгтгэн, тэдгээрийг шалтгаант холбоог судлан, гарч болзошгүй хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлогоор хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	ЭТГ ЭМХТ ЭХЭМҮТ	НЭМГ	2018-2019	Өсвөр насны охидын төрөл зулбалт, үр хөндөлтийн мэдээллийг нэгтгэсэн байна
13	Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эх барих эмч, мэргэжилтнүүдийн багтлагдсан орон тоог бүрэн хангах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	ЭҮТГ	БТГ ТЗҮГ ХОХ	2018-2019	Багтлагдсан орон тоог бүрэн шаардлагатай тоног төхө хангасан байна
14	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн өсвөр насны охидын боловсрол эзэмших	БТГ	НЭМГ	2017-2019	Өсвөр насны охидын б эзэмших үйл явцыг хувилбаргаар хичээлийн нэмсэн байна

	Үйл явц, сургуульд хамрадалтанд анхаарал хандуулж, боломжит хувилбараар ерөнхий боловсролыг завсардалтгүй болгох						
15	Эмч, эмнэлгийн байгууллагын ажигтнуудын мэргэшил, мэргэжлийн ёс зүй, хүний эрхийн боловсролд анхаарал хандуулах сургалтын үр нөлөөг үнэлэх, хүртээмжийг сайжруулах	ТЗУГ	ЭТГ	2017-2019	Мэргэжлийн ёс зүй болон хүний боловсролын чиглэлээр сурга шат дараатайгаар зохион б хүртээмжийг сайжруулсан байна;		
16	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд байгаа Асрамжийн клиникт асруулж буй сэтгэцийн эмгэгтэй давхар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн орчин нөхцөлийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн сайжруулах, тэдний хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	НЭМГ ЭТГ ТЗУГ	БТГ ХОХ	2018-2019	Сэтгэцийн эмгэгтэй давхар ; бэрхшээлтэй хүүхдүүдийн хэ тохирсон тусгай хэрэглэгд хангагдсан байна		
17	Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс настны эмгэг судлалын төрөлжсөн мэргэжлийн тусламжийг шатлал бүрт өргөжүүлэн хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэн чадавхжуулах	ЭМХТ	ЭТГ ТЗУГ ГТТ	2018-2019	Настны эмгэг судлалын т мэргэжлийн тусламжийг шат өргөжүүлэн хөгжүүлсэн, хүний бэлтгэн чадавхжуулах сурге шаттайгаар зохион байгуулсан		